

# 2021

Хувьцаа  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Бүртгэл	10 минут
Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	5 минут
Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах	5 минут
Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах	5 минут
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг танилцуулах	5 минут
Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах	10 минут
Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай хэлэлцэн батлах	10 минут
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах	10 минут
Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах	5 минут
Асуулт, хариулт	20 минут
Саналын хуудсаар санал авах	10 минут
Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	30 минут
Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах	10 минут

Хурлын үргэлжлэх хугацаа

2 цаг 15 минут

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

## ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 3 сарын 19 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр /Zoom/ хуралдуулсугай.
2. ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
  2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №19 “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг танилцуулах;
  4. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;
  5. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай хэлэлцэн батлах;
  6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах;
  7. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах;
  8. Бусад
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1-ээр “Хурлын дэг”-ийг Хавсралт №2-оор, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас”-ыг Хавсралт №3-аар, “Хурлын зар”-ыг Хавсралт №4-өөр тус тус баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цаг хүртэл компанийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай. Үүнд:
  1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон тус тогтоолд холбогдох хавсралтуудын хуулбарууд,

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

## 2. Компанийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хуулбар

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2021 оны 3 дугаар сарын 21-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэх, Хавсралт №4-ийн дагуу хурлын зарыг 2021 оны 3 дугаар сарын 24-ний дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээлэх, 2021 оны 3 дугаар сарын 28-ны дотор брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.
7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн ээлжит хурлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Золжаргал, комиссын гишүүнээр Ч.Тэмүдэр, хурлын нарийн бичгийн даргаар Б.Бадамцэцэг нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар Л.Идэрзаяа, тооллогын комиссын гишүүнээр Г.Азбилэг, Ж.Ганхүлэг нарыг тус тус томилсугай.
10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн  
2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн  
17 тоот тогтоолын Хавсралт №1

## ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Аризона төв 1-11 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2021 оны 4 сарын 30 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Цахим/Zoom/
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2021 оны 3 сарын 19 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2021 оны 3 сарын 24 өдөр
Бүртгэлийн өдөр:	2021 оны 4 сарын 12 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2021 оны 3 сарын 28 өдөр /Цахимаар/
Хүргүүлсэн огноо:	2021 оны 3 сарын 19 өдөр
Саналын хуудас хүлээн авах сүүлийн өдөр	2021 оны 4 сарын 29 өдөр 17 цаг хүртэл
Хурлын даргын нэр:	Ч.Чинзориг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Л.Идэрзаяа, Г.Азбилэг, Ж.Ганхүлэг
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	ширхэг ...
	хуудас ...

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

  
.....

/Б.Золжаргал/

2021 оны 3 сарын 19 өдөр

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн  
2021 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн  
17 тоот тогтоолын Хавсралт №3

## ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №1

Компанийн оноосон нэр: ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК  
Байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Аризона төв 1-11 тоот  
Хурал хуралдах огноо: 2021 оны 4 сарын 30-ны өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:				
Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа төлөөлөгч этгээдийн тухай тайлбар:				
Регистрийн дугаар:				
Санал өгөх хувьцааны тоо:				
Утасны дугаар:				
Цахим хаяг:				
Хэлэлцэх асуудал		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;			
2	Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;			
3	Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай хэлэлцэн батлах;			
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах;			
5	Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах;			
6	Бусад			

Заавар: Та өөрийн саналыг (+) тэмдгээр бичнэ.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг : ..... /

Тооллогын комисс бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм  Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл: .....



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ



## ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Хурлын төрөл:	Ээлжит
Хурал хуралдах өдөр, цаг:	2021 оны 4 сарын 30 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар	Цахим/Zoom апплэйкшн/
Бүртгэлийн өдөр:	2021 оны 4 сарын 12 өдөр
Хэлэлцэх асуудал:	<ol style="list-style-type: none"><li>1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;</li><li>2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;</li><li>3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын №19 “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг танилцуулах;</li><li>4. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;</li><li>5. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай хэлэлцэн батлах;</li><li>6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах;</li><li>7. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах;</li><li>8. Бусад</li></ol>
Баримт бичигтэй танилцах:	2021 оны 4 сарын 26 өдрөөс 2021 оны 4 сарын 29 өдрийн 17:00 цаг хүртэл
Холбоо барих:	info@vik.mn tandeminvest.nbfi@gmail.com 94002977;99074804

# ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

КОМПАНИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТИЙГ  
ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

ДҮРМИЙН САН НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЭМЖ АВАХ ТУХАЙ  
ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ТӨСӨВ  
ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

КОМПАНИЙН ДҮРМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

# 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



**ШИНЭ ИХ ТЭРБУМ  
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот  
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

2021-02-09 № 21/06  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид “Тандэм инвест ББСБ” ХК (цаашид “ББСБ” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Аудитын ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авсан горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үйл явц үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзан үзсэн. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлуудыг багтаасан болно.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав. Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.



# 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ) “ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид танаа**

---

### **Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудал**

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

### **Аудитын гол асуудал**

Аудиторын мэргэжлийн үнэлэмжээр “аудитын гол асуудал” гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс болно. 2020 оны 1-р сараас дэлхий нийтээр тархсан Коронавируст халдвар (“Ковид-19”)-ын цар тахлын нөлөөллөөс хамааран ББСБ-ын харилцагчдын зээл болон хүүгийн эргэн төлөлт нь хугацаандаа төлөгдөхгүй байх эрсдэлтэй болсон. Бид энэхүү асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

### **Бусад асуудал**

Коронавируст халдварын цар тахлаас сэргийлэх үүднээс Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн ээлжит хуралдаанаар 2020 оны 12 дугаар сарын 14-нөөс эхлэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн. Энэ нөхцөлд бид аудитын ихэнх хэсгийг зайнаас ажиллаж гүйцэтгэсэн болно.

Аудитын зорилгоор авч ашигласан мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэд, найдвартай болохыг ББСБ-ын удирдлага хариуцах болно. Санхүүгийн тайлангийн аудитыг дээр дурдсан нөхцөлд хийсэн болохыг хэрэглэгчдийн анхааралд хүргэж байна. Үүнээс шалтгаалж манай аудитын дүгнэлт өөрчлөгдөхгүй.

### **Бусад мэдээлэл**

ББСБ-ын Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”), хэрвээ байхгүй бол гүйцэтгэх удирдлага нь бусад мэдээллийг бэлтгэх үүрэгтэй. Бусад мэдээлэл нь ТУЗ-ийн тайлангийн хавсралт, бизнесийн хариуцлагын тайланг багтаасан мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбогдуулан бидний үүрэг бол бусад мэдээлэлтэй танилцах бөгөөд бусад мэдээлэл нь бие даасан санхүүгийн тайланд эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх талаар авч үзэх явдал юм. Энэ талаар бидэнд мэдээлэх зүйл байхгүй болно.

### **ББСБ-ын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

# 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ) “ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид танаа**

### **ББСБ-ын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага (үргэжлэл)**

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь ББСБ-ын тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлэх, тодруулга бэлтгэх, ББСБ-ыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх үүрэг хүлээнэ. Засаглах удирдлага нь ББСБ-ын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

### **Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) -ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон түүний тодруулгуудыг нотлох горимуудыг гүйцэтгэх ажил багтдаг. Аудитын явцад ББСБ-д хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, тайлангууд бодитой эсэхэд дүгнэлт өгсөн болно.

### **Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн ББСБ-ын хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ц.Мишигдорж - Захирал, МНБ



# 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## "ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ" ХК

### АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

#### БАЛАНС

	12/31/2020	12/31/2019
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	444,314,802	5,880,474
Зээл (цэвэр)	1,876,525,413	2,160,591,495
Бусад авлага	128,894,583	86,133,630
Бусад хөрөнгө	2,559,530	2,547,551
Үндсэн хөрөнгө (цэвэр)	22,449,069	15,001,695
Биет бус хөрөнгө (цэвэр)	143,000	715,000
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,474,886,397</b>	<b>2,270,869,845</b>
Бусад өр төлбөр	2,765,146	12,264,302
Хувьцаат капитал	1,988,698,380	1,988,698,380
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	483,422,871	269,907,162
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>2,474,886,397</b>	<b>2,270,869,844</b>

#### ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хүүгийн орлого	643,171,781	606,889,840
Хүүгийн бус орлого	9,752,289	19,723,638
Хүүгийн бус зардал	235,219,947	220,224,756
Болзошгүй эрдэлийн зардал	181,026,714	67,960,016
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>236,677,409</b>	<b>338,428,706</b>
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	13,073,117	12,234,935
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>223,604,292</b>	<b>326,193,771</b>
Орлогын албан татвар	10,094,150	35,079,719
<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>213,510,142</b>	<b>291,114,052</b>

#### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хувьцаат капитал	1,992,267,900	1,992,267,900
Халаасны хувьцаа	(3,569,520)	(3,569,520)
Хуримтлагдсан ашиг	483,422,872	269,907,162
<b>Нийт эздийн өмчийн дүн</b>	<b>2,472,121,252</b>	<b>2,258,605,542</b>

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	2,860,130,043	3,438,908,533
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	2,396,202,598	3,546,142,170
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>463,927,446</b>	<b>(107,233,636)</b>
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	125,000,000
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	25,493,117	12,234,935
<b>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(25,493,117)</b>	<b>112,765,065</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>438,434,329</b>	<b>5,531,429</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,880,474	349,045
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>444,314,802</b>	<b>5,880,474</b>

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

